



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/751

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөгч хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.4.3-т заасны дагуу Төлөөлөгч Л.Цэнд-Аюуш БНХАУ-д туршлага судлах зардалд 2000000 төгрөг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт /Хөшөөт хөгжил сан/ 5.3 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ